



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 8 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 222

Улаанбаатар  
хот

## Жагсаалт шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.20, 9.1.21-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгож байгаа 1.0 (нэг) тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Хавсралтад дурдсан төслийг БНХАУ-ын Засгийн газарт санал болгож, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, холбогдох сайд нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн тухай” Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 458 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ж.ЭРДЭНЭБАТ

Б.ЧОЙЖИЛСҮРЭН



Засгийн газрын 2017 оны 222 дугаар  
тогтоолын хавсралт

БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт  
олгох хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр  
хэрэгжүүлэх төслийн жагсаалт

№	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг (сая ам.доллар)	Зээлийн санхүүжилт -95% (сая ам.доллар)	Төсвийн санхүүжилт -5 % (сая ам.доллар)
1	“Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих” төсөл	119.0	113.0	6.0
2	“Гачууртын уулзвараас Налайх- Чойрын уулзвар хүртэлх 20.9 км замын өргөтгөл, шинэчлэл” төсөл	38.2	36.3	1.9
3	“Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл” төсөл	51.8	49.2	2.6
4	“Өрсөлдөх чадвартай дээд боловсрол” төсөл	25.0	23.8	1.2
5	“Туул, Сэлбэ гол орчмыг сайжруулах төсөл”	60.0	57.0	3.0
6	“Нүхэн гарц” төсөл	40.0	38.0	2.0
7	“Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар хяналтыг сайжруулах” төсөл	22.1	21.0	1.1
8	“Улаанбаатар хот, аймгийн төвийн гудамж, талбайг камержуулах” төсөл	30.0	28.5	1.5
9	“Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам” төсөл	400.0	380.0	20.0
10	Дэд бүтэц, авто зам, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарын хөгжлийн багц төслүүд	266.5	253.2	13.3
Нийт		1,052.6	1,000.0	52.6